



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/513

Чойбалсан

Г Үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт
оруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 14.2.7 дахь заалт, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 400 дугаар тушаал, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын 2022 оны хоёрдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Шони мед” ХХК-ийн “Шони мед” эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2.Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг “Шони мед” ХХК-ийн захиралд үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба (Ч.Оюунаа), Мэргэжлийн хяналтын газар (Д.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

0101 1427

Аймгийн Засаг даргын 2022 оны
09 дугаар сарын 20 ны өдрийн
05 дугаар захирамжийн хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны чиглэлийн нэмэлт өөрчлөлт
1	“Шони мед” ХХК	“Шони мед” эмнэлэг	ЭХ-20/09/3921	Эхо оношилгоо, хүүхэд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ	Дүрс оношилгоо, дотор, уламжлалт, сэргээн засах чиглэлийн тусламж үйлчилгээ